

ХИЧЭЭЛ 6

УНШИХ ЗҮЙЛ: ДАНИЕЛ 2:1-28, 46-49; ЗӨНЧИД БА ХААД, Х. 491-502.

Хааны Зүүд

Та нар зүүд зүүдэлж байсан уу?
Сэрснийхээ дараа зүүднийхээ тухай
бодоход гоё байдаг уу? Эрт дээр үед
нэгэн хаан их сонин зүүд зүүдэлжээ.

Н

ебухаднезар хаан
орондоо хөрвөөж их
л хэцүү байлаа.
Тэр нүдээ нээгээд
эргэн тойрныг
харав. Харанхуй

хэвээр л байлаа. Хаан саяхан
зүүдэлсэн хачин зүүднийхээ тухай бодсоноо
эргэн унтах гэж оролдсон боловч чадсангүй.



Цээжлэх Ишлэл:

"Их Эзэний ивээлийн
тухай сайн мэдээг би
хүмүүст хэлмээр
байна"

ҮЙЛС 20:24.

Тол Санаа:

Бид Их Эзэний тухай
хүмүүст ярьснаараа
Түүнийг хүндэтгэдэг.

"Мэргэдийг хурдан цуглуул" гэж тэр зарц нартаа
хэлэхэд зарц нар зарим мэргэдийг сэрээн хаан дээр
бушуухан авчирлаа.

Хаан Небухаднезар мэргэдэд "Би нэгэн зүүд
зүүдэллээ" гэхэд мэргэд "Хаантан, мөнх наслах болтугай.
Зүүдээ хэлж өгөөч тэгвэл бид танд ямар утгатай болохыг
нь хэлж өгье" гэжээ.

"Үгүй ээ, та нар зүүдийг минь хэл. Тэгээд бас ямар
утгатай болохыг нь ч хэл" гэж хаан хашгирлаа.

Мэргэдүүд бие бие рүүгээ харлаа. Тэдний царайнд

огтхон ч инээмсэглэл тодорсонгүй. Харин "Хэн ч түүний хэлснийг хийж чадахгүй шүү дээ" гэж шивнэлдэв.

Небухаднезар хаан ихэд уурлан "Тэднийг аваад яв, бүх мэргэдийг аваад яв" гэлээ.

Мэргэдүүдийн нэг болох Даниел унтаж байтал зарц нар түүнийг сэрээж, Даниел тэднээс юу болсныг мэдэж авчээ. "Юу болоо вэ?" гэж Даниел асуухад зарц нар учрыг тайлбарлан "Хаан нэг зүүд зүүдэлжээ. Бусад мэргэдүүд үүнийг тайлж чадахгүй байна" гэв.

Даниел "Гуйж байна, намайг хаантай уулзуулаач" гэж асуув. Ингээд Даниел явсаар хааны өмнө бөхийн ёслол "Надад хугацаа өгөөч, Би Их Эзэндээ залбирч Түүнээс таны зүүдийг болон ямар утгатайг нь асуух гэсэн юм" гэхэд хаан зөвшөөрлөө.

Даниел гурван сайн найз дээрээ очоод Их Эзэнээс зүүдний нууцыг тайлахын төлөө хамтдаа залбирцгаав. Тэр шөнө Их Эзэн Даниелд хааны зүүдний утгыг нь тайлж өгөв.

Өглөө болоход Даниел Небухаднезар хаан дээр эргэн очиход хаан түүнээс "Чи миний юу зүүдэлснийг хэлж чадах уу?" гэхэд Даниел "Үгүй, би чадахгүй.

Гэвч тэнгэрт бүх нууцыг мэддэг нэгэн Эзэн Бурхан бий" гээд хаанд юу зүүдэлснийг нь болон ямар утгатайг нь хэлж өгчээ.

"Яг зөв, одоо би чиний Их Эзэн хамгийн агуу нь гэдгийг мэдлээ" гэж хаан хашгирав.

Небухаднезар хаан Даниелыг захирагч болгон мэргэдүүдийг удирдах ажил хариуцууллаа. Даниел мэргэдүүдийг хүнд байдлаас гаргасандаа баяртай байсан бөгөөд хамгийн гол нь хаан цорын ганц үнэн Их Эзэнийг мэдэж авсанд хамгийн их баяртай байлаа.



Дасгал Ажил

ШАББАТ

Энэ долоо хоногийн өдөр бүр хичээл дээр үзсэн түүхээ хамтдаа уншаад цээжлэх ишлэлээ заахдаа дараах хөдөлгөөнийг хийгээрэй.

- Би**Өөрийгөө заах.
- Их Эзэний**Дээшээ заах.
- ивээлийн тухай**
- сайн мэдээг**Гараа алдлан дэлгэх.
- хүмүүст**Бусдыг заах.
- хэлмээр байна.**Хуруугаараа уруулдаа хүргэж дараа нь гараа бэлхүүс хүртлээ буулгах.
- Үйлс 20:24**.....Алгаа нийлүүлээд дэлгэнэ.

НЯМ

Шаббат хичээл дээр хийсэн хаалгаа хөрштэйгөө эсвэл найзтайгаа хуваалцахад нь хүүхдээ урамшуулаарай. (Эсвэл шинээр хаалга зурж будахад нь хүүхдэдээ туслаад дараах үгүүдийг дээр нь бичиж өгөөрэй. Дин дин, Хэн бэ?, Үү, Үү гэж хэн бэ? Та Есүсийн тухай мэдэх үү?)

ДАВАА

Цэцэг хайчилж эсвэл бялуу хийж, зураг зураад хөршдөө өгч тэдэнд Есүс хичнээн хайртай гэдгийг нь хэлэхэд хүүхдэдээ туслаарай.

Хүүхдийн тань бүх найзууд Есүсийг хайрлахын төлөө хүүхэдтэйгээ хамтдаа гуйгаарай.


МЯТМАР

Туслах, сонсох, ярилцах гэх мэт Есүсийн тухай бусдад ярьж өгөх арга замуудыг

сэтгүүл болон ном сонингоос хараарай. Бусадтай Есүсийг хуваалцах арга замуудыг хүүхдээрээ жүжиглүүлээрэй.

ЛХАГВА

Хүүхэд тань нэгээс арвын хооронд нэг тоо бодож та тэр тоог таагаарай. Та тоог зөв таах хүртлээ хэдэн удаа алдсан бэ? Солигдоод таагаад үз. Зөвхөн Их Эзэн л бидний бодол болон зүүдийг мэдэж байдаг тухай ярилц.



ПҮРЭВ

Даниел 2:1-28, 46-49-г хамтдаа уншаад "Хаан мэргэн хүмүүсээр юу хийлгэхийг хүссэн бэ? Тэд яагаад чадаагүй вэ? Небухаднезар хаан Их Эзэний тухай юу мэдэж авсан бэ? Бусад хүмүүс Их Эзэний тухай чамаас юу мэдэж чадах вэ?" гэж асуу.

Зүүдэлсэн зүүдийг нь хүүхдээрээ зуруулж яриулаарай. Өөрийнхөө гоё зүүднүүдээс хүүхдэдээ ярьж өг. Сайхан зүүд өгсөнд нь Есүст талархаарай.

БААСАН

Гэр бүлийн залбирлын үеэр Библийн түүхийг хамтдаа жүжиглээд "Их Эзэний захиас" гэдэг тоглоом тоглоорой. Их Эзэний тухай ямар сайн зүйлийг бусдад ярьж өгөх талаар бодоод тойргоор эхлэн бие биенийхээ чихэнд шивнэж хэлээрэй.

